

“ХҮНДЭТ ДОКТОР” ЦОЛ ОЛГОВ

Шинжлэх ухааны хүрээлэнгийн дарга асан (1940 он, 1946-1950 онд), нэрт дипломатч Б.Жаргалсайханы 90 насны ойд зориулж Гадаад Хэргийн Яам, Шинжлэх Ухааны Академи, Монголын Зохиолчдын Эвлэлийн Хороо хамтран уулзалт бага хурал зохион байгууллаа.

Монголын шинжлэх ухааны төв байгууллагыг бүх талаар бэхжүүлэх, боловсон хүчний мэдлэг чадварыг дээшлүүлэх, гадаадын эрдэм шинжилгээний байгууллага, эрдэмтэдтэй нягт холбоо тогтоож хамтран ажиллах талаар хийсэн түүний бүтээлийг үнэлж Б.Жаргалсайханыг Монгол Улсын ШУА өөрийн байгууллагын хүндэт дэвтэрт бичиж алдар гавьяаг нь мөнхжүүлж, түүнд өргөмжлөл жуух гардуулан баяр хүргэлээ.

Бага хуралд ШУА-ийн дэд өрөнхийлөгч, академич Б.Энхтүвшин, академич П.Хорлоо нар дэлгэрэнгүй үг хэлж Б.Жаргалсайханы шинжлэх ухааны салбарт оруулсан хөдөлмөр бүтээлийн талаар тодорхой ярилаа.

Мөн ШУА-ийн Олон Улс Судлалын Хүрээлэнгийн Эрдмийн зөвлөлийн шийдвэрээр “Хүндэт доктор” цол өргөмжлөв. Энэ ёслол дээр Олон Улс Судлалын Хүрээлэнгийн захирал, доктор профессор Л.Хайсандай хэлсэн үгэндээ: “Одоогоос 55, 65 жилийн тэртээ энэхүү эрдмийн өргөө, өрх гэрийн эзэн нь байсан өдгөө 90 насыг зооглон яваа буянтай сайхан энэ буурал олон арван жил улс Монголынхоо төлөө, хүн ардынхаа тусын тулд ажил амьдралаа зориулж ирсэн алдар гавьяатай. Энэ хүн бол эрдэм номын хувьд ч, элчин харилцаа, дипломат албын хувьд ч эгэл жирийн атлаа өндөр нэр хүндтэй, алдрын замыг туулжээ. Энэ зам мөр нь ямагт ариун цагаан байсан бөгөөд үүгээрээ бидний бахархал бишрэлийг төрүүлж байна.

Жаргалсайхан гуай дэлхийн хэмжээнд нүд тайлж, дэлхийн хэмжээний хүмүүстэй уулзан учирч, дэлхийн хэмжээнд бодож сэтгэж, хийж бүтээж явсны гэрч баталгаа нь түүний бичиж туурвисан олон сайхан ном байна. Эдгээр номонд дурсаж өгүүлсэн, бичиж хүүрнэсэн үйл явдал бүхэн нь, ургуулж бодсон уран санаа, ухаалаг хэрсүү үг, өгүүлбэр бүр нь бид бүхэнд, манай залууст, Монголын олон улс судлалын үйл хэрэгт ихээхэн ач тустай, үнэ цэнэтэй юм” гэж онцлон тэмдэглэлээ.

ШУА-ИЙН ОЛОН УЛС СУДЛАЛЫН ХҮРЭЭЛЭНГИЙН ЗАХИРАЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ДОКТОР, ПРОФЕССОР ЛУВСАНГИЙН ХАЙСАНДАЙН ХЭЛСЭН ҮГ

Эрхэм хүндэт ШУА-ийн Ерөнхийлөгч өө!

Эрхэм хүндэт Гадаад хэргийн сайд аа!

Эрдэм номын андууд аа!

Хатагтай, ноёд оо!

Та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгая!

Та бид Монголын шинжлэх ухааны гал голомт болсон ШУА-ийн төв байранд хүрэлцэн ирээд байна. Эндээс зөвхөн эрдэм номын дуу хоолой цуурайлж, энд зөвхөн эрдэм номын уур амьсгал “ноёрхож” байдаг газар аа! Одоогоос 55, 65 жилийн тэртээ энэхүү эрдмийн өргөө, өрх гэрийн эзэн нь байсан хүн өнөөдөр та бидний дунд морилж байна. Энэ хүн бол та бидний бахархан хүндэлдэг Баярын Жаргалсайхан гуай юм. Тэрбээр өдгөө 90 насыг зооглон яваа буянтай сайхан буурал аа! Ач буянтай энэ буурай маань олон арван жил улс Монголынхоо төлөө, хүн ардынхаа тусын тулд ажил амьдралаа зориулж ирсэн алдар гавъяатай. Энэ хүн бол эрдэм номын хувьд ч, элчин харилцаа дипломат албын хувьд ч эгэл жирийн атлаа өндөр нэр хүндтэй, алдрын замыг туулжээ. Энэ зам мөр нь ямагт ариун цагаан байсан бөгөөд үүгээрээ бидний бахархал бишрэлийг төрүүлж байна.

Б.Жаргалсайхан гуай дэлхийн хэмжээнд нүд тайлж, дэлхийн хэмжээний хүмүүстэй нүүр учирч, дэлхийн хэмжээнд бодож сэтгэж, хийж бүтээж явсны гэрч баталгаа нь түүний бичиж туурвисан хэдэн сайхан номнууд байна. Эдгээр номонд дурсаж өгүүлсэн, бичиж хүүрнэсэн үйл явдал бүхэн нь, ургуулж бодсон уран санаа, ухаалаг хэрсүү үг өгүүлбэр бүр нь бид бүхэнд, манай залууст, Монголын олон улс судлалд ихээхэн ач тустай, үнэ цэнэтэй болохыг онцлож хэлье.

Б.Жаргалсайхан гуай Монгол Улсын шинжлэх ухааны хүрээлэнг удирдан, зохиолчдын эвлэлийг толгойлж галыг нь бадрааж, хийморийг нь сэргээж явсан түүхтэй, ач тустай хүн. Чингэснээрээ олон найз нөхөр, олон сайхан шавьтай хүн.

Б.Жаргалсайхан гуай бол бас өөрийг нь нэр төртэй залгамжилж яваа эрдэм ухаан, авъяас билиг нь тэгширсэн хүү, охин, ач, зээ олонтой хүн. Тухайлбал, хүү Энхсайхан нь сайн эцгийн шийрийг хатааж яваа манай шилдэг залуу дипломатч төдийгүй,

эрдмийн ажилд ихээхэн дур сонирхолтой, авъяастай, гадаад хэлний өндөр боловсролтой залуу байгаа юм. Тэрээр манай хүрээлэнгээс эрхлэн англи хэлээр нийтэлдэг цорын ганц хэвлэл “Монголын гадаад харилцаа” сэтгүүлийг бэлтгэж хэвлүүлэхэд бүх талаар, маш идэвхитэй дэмжин тусалж байдаг ба тус сэтгүүлийн зөвлөлийн хамгийн идэвхитэй ажил хэрэгч гишүүн нь, хөтөч нь байгаа юм.

Чингээд их эзэн Чингис хааны гэрээслэсэн мөнхийн айлдварын нэг Монгол төрийн алтан аргамжаа болсон элчин харилцаа, дипломат албыг хөгжүүлэхэд жинтэй хувь нэмэр оруулсан манай нэртэй ахмад дипломатч Баярын Жаргалсайхан гуайдаа ШУА-ийн Олон Улс Судлалын Хүрээлэнгийн Эрдмйн Зөвлөлийн шийдвэрээр “Хүндэт Доктор”-ын цол өргөмжилж байна.

Эрхэм хүндэт Б.Жаргалсайхан гуай Та энэхүү өргөмжлөлийг соёрхож, “Хүндэт Доктор-ын өмсгөлөө өмч, дипломоо гардан авна уу.

